

## ТАЙЛАН 2017

- 1.
- 2. *Төлөвлөгөө*: НМХГ-ын Ёс зүйн хороо нь байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны төлөвлөгөөг 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Ёс зүйн хорооны 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан.
- 3. *Сургалт*: Албан хаагчдыг ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдөр шинээр томилогдсон улсын байцаагчдад зориулан зохион байгуулсан сургалтанд Ёс зүйн хороо, түүний үйл ажиллагаа, Төрийн албан хаагчийн ёс зүй, 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр БГД дэх МХХ-ийн улсын /ахлах/ байцаагчдад “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлийн тухай”, 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Төв Лабораторийн албан хаагчдад “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлийн тухай” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан.
- 4. *Сурталчилгаа*: НМХГ-ын цахим хуудсанд 2016 оны ёс зүйн зөрчлийн мэдээ, ёс зүйн хорооны үйл ажиллагааны талаар мэдээллийг шинэчлэн байршуулан ажилласан.
- 5. *Ёс зүйн зөрчлийн талаар*: 2017 оны байдлаар НМХГ-ын Ёс зүйн хороонд нийт 17 өргөдөл, гомдол ирснээс төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдолтой холбоотой 13, улсын /ахлах/ байцаагчийн үнэмлэхээ үрэгдүүлсэн 4 асуудал байна. Ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдөл гомдлыг судлан шалгаж Ёс зүйн хорооны хуралдааныг 7 удаа зарлан хуралдуулж өргөдөл гомдлыг 100% шийдвэрлэн ажилласан.
- Мөн ёс зүйн зөрчилтэй гэх 3 гомдлыг судлан ажиллах явцад талууд эвлэрсэн 1, ёс зүйн маргаан үүсгэх үндэслэлгүй 2 асуудлыг харьяаллын дагуу Дотоод хяналт, шалгалт, мониторингийн хэлтэст шилжүүлсэн.
- 5. *Архив, албан хэрэг хөтлөлт*: Ёс зүйн хорооны 2016 оны хурлын тэмдэглэл, дүгнэлт, үйл ажиллагаатай холбогдолтой тайланг архивын нэгж болгон хавтаслан архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн.